



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 12 дугаар сарын 17

Дугаар 6

Улаанбаатар хот

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН VI ХУРАЛДААН

Улсын онцгой комиссын хуралдаан 2024 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 10.00 цагт Төрийн ордон дахь "Сүхбаатар танхим"-д 80 хувийн ирцтэй эхэлж 12.00 цагт дуусав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, хугацаатай үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Улсын онцгой комиссын Шуурхай штабаас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

*Онцгой байдлын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга
бөгөөд штабын дарга, хурандаа Ц.Ганзориг*

2. Ирэх саруудын цаг агаарын төлөв байдлын талаар

*Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Оюунжаргал*

3. Нийслэлийн агаарын чанарын төлөв байдлын талаар

*Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Оюунжаргал*

4. Агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар

*Нийслэлийн Засаг даргын Нийгмийн салбар,
ногоон хөгжил болон агаар орчны бохирдлын асуудал
хариуцсан орлогч А.Амартүвшин*

5. Шахмал түлшний үйлдвэрлэл, чанар, стандартад хийсэн лабораторийн шинжилгээ, үр дүнгийн талаар

*Таван толгой түлш ХХК-ийн ерөнхий технологич
Д.Өлзийбат*

6. Нийслэлийн агаарын бохирдлын асуудлаар Шадар сайд, Улсын онцгой комиссын даргын 2024 оны 12 дугаар сарын 6-ны өдрийн хурлаар өгсөн үүргийн хэрэгжилт

*БОУАӨЯ, ЭХЯ, ЦЕГ, ЦУОШГ, Нийслэлийн агаар, орчны
бохирдолтой тэмцэх газрын холбогдох албан тушаалтнууд*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Н.Учралд:

1.1. Агаарын бохирдлыг бууруулах, агаарын чанарыг сайжруулах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах, салбар дундын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, хяналт тавих, хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий Үндэсний хороо байгуулах асуудлыг Засгийн хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлүүлэх,

Хоёр. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатар:

2.1. Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах, агаарын чанарыг сайжруулах үйл ажиллагааг хариуцан зохион байгуулах чиг үүрэг бүхий холбогдох мэргэжлийн байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн Нийслэлийн Онцгой комиссын Шуурхай штабыг байгуулж нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах, хяналт тавих,

Гурав. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуянд:

3.1. Улсын онцгой комиссын даргын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 10 дугаар тушаалаар байгуулагдсан Шуурхай штабыг үйл ажиллагааг өргөжүүлэн зохион байгуулж, агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй Нийслэлийн онцгой комисст дэмжлэг үзүүлж, салбар дундын үйл ажиллагааг зохицуулж, удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллах,

Дөрөв. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Одонтуяа, Эрчим хүчний сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатар, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Т.Сүхболд нарт:

4.1. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх хууль тогтоомж, журмын хэрэгжилтэд хяналт шалгалт зохион байгуулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчин агаар, орчныг бохирдуулж байгаа үйлдлийг таслан зогсоох, "Агаарын чанарын сайжруулах бүсэд мөрдөх журам"-ыг зөрчин хууль бусаар түүхий нүүрс хэрэглэсэн, бусад хориглосон шатах материал /автомашин дугуй, хуванцар гэх мэт/ түлсэн эсэхийг нэг бүрчлэн шалгаж, илэрсэн зөрчлийг арилгуулах, хариуцлага тооцох, ажлын явц, үр дүнг 14 хоног тутам Улсын онцгой комисст танилцуулж ажиллах,

4.2. Хяналт шалгалтын ажилд төрийн байгууллагуудын албан хаагчдыг татан оролцуулах, шаардлагатай зардлыг батлагдсан төсөвтөө багтаан шийдвэрлэх,

4.3. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд түүхий нүүрс түлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаа, утааны шүүлтүүрийн ашиглалтад хяналт шалгалт зохион байгуулах, хууль, журмын хэрэгжилтийг хангах,

4.4. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх хууль тогтоомж, журмын хэрэгжилтэд хяналт тавих ажилд иргэд, аж ахуйн нэгж байгууллагын оролцоог хангах, хорооны Засаг дарга, хэсгийн ахлагч нарын үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх,

Тав. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн С.Одонтуяа, Эрчим хүчний сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Чойжилсүрэн, Тагнуулын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал П.Одонбаатар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Т.Сүхболд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатар нарт:

5.1. Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр урт, дунд, богино хугацаанд авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн нарийвчилсан төлөвлөгөө гарган батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллах,

5.2. Сайжруулсан шахмал түлшний чанар, стандартад тогтмол хяналт тавьж ажиллах, гадаадын хөндлөнгийн байгууллагуудаар нарийвчилсан шинжилгээ хийлгэж, үр дүнг 14 хоногт багтааж Улсын онцгой комисст танилцуулах,

Зургаа. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайханд:

6.1. Томуу, томуу төст өвчний өвчлөл нэмэгдэж байгаатай холбогдуулан халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлыг өргөн хүрээнд явуулж, эмнэлгийн тусламж үйлчилгээг оновчтой, үр дүнтэй, хүртээмжтэй зохион байгуулах, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ явц, үр дүнг 7 хоног тутам Улсын онцгой комисс, Засгийн газрын хуралдаанд танилцуулах,

6.2. Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч болзошгүй зарим аймаг, сумдад эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтийн асуудлаас шалтгаалж тусламж үйлчилгээ доголдох эрсдэл үүссэн асуудлыг холбогдох хууль, журмын хүрээнд яаралтай шийдвэрлэж, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнг 14 хоногт багтаан Улсын онцгой комисст танилцуулах,

Долоо. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Батсуурьт:

7.1. Хүйтний улиралд барилга угсралтын ажлыг үргэлжлүүлэн явуулж, газар гэсгээх зорилгоор түүхий нүүрс, сайжруулсан шахмал түлш ил задгай түлж буй аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт шалгалт зохион байгуулах, хууль, журам зөрчсөн үйл ажиллагааг таслан зогсоож, явц үр дүнг 14 хоног тутамд Улсын онцгой комисст танилцуулах,

Найм. Батлан хамгаалахын сайд, Улсын онцгой комиссын орлогч дарга С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн О.Алтангэрэл, Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Т.Мөнхсайхан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Улсын онцгой комиссын гишүүн Х.Нямбаатар нарт:

8.1. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудын усан халаалтын зуухнуудад технологийн шинэчлэлийг хийх, зуухыг солих арга хэмжээг нэн яаралтай авч хэрэгжүүлэх,

Ес. Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нарт болон Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газарт:

9.1. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх хууль тогтоомж, журмын хэрэгжилтэд хяналт тавих, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг зөрчин агаар, орчныг бохирдуулж байгаа үйлдэлд хяналт шалгалт зохион байгуулах үйл ажиллагаанд салбарын хяналтын байцаагч нарыг холбогдох хууль журмын дагуу дайчлан ажиллуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас авч хэрэгжүүлж буй үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хяналт шалгалтын явц, үр дүнг тухай бүр Улсын онцгой комисст танилцуулж ажиллах,

Арав. Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Т.Ганзулд:

10.1. Нийслэлийн агаарын чанарыг сайжруулах бүсэд мөрдөх хууль тогтоомж, журмын хэрэгжилт, угаарын хийн мэдрэгчийн ашиглалт, пийшин, зуух, яндан, цахилгааны болон галын аюулгүй байдал хангах, болзошгүй осол, аюулаас урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан олон нийтэд тогтмол хүргэх,

Арван нэг. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

11.1. Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 28 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаагүй, өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг бүрдүүлэлгүй худал мэдээ, мэдээлэл гаргасан албан тушаалтнуудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох,

11.2. Өвөлжилтийн бэлтгэл ажлыг дутуу хангасан сумдын бэлтгэл ажлыг нөхөн хангуулах, буруутай этгээдэд холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцох,

Шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, танилцуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

